



Үндэсний аудитын газрын харьяа
Хэнтий аймгийн аудитын газар

ХЭАГ-2016/01-ГА-ХЭ

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ
АЖИЛД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫГ ХУУЛЬД ЗААСАН
ХЭМЖЭЭГЭЭР БАТЛАХГҮЙ БАЙНА.**



6/15/2016

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн Хэнтий аймгийн Аудитын газар Тэргүүлэх аудитор: Ц.Энхтүвшин Аудитын менежер: Б.Наранцэцэг Ахлах Аудитор: Н.Туяа Аудитор: Ү.Төгсжаргал, Ц.Нарангэрэл Шинжээч: Д.Эрдэнэбилэг 2014 оны 09 дугаар сар Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймгийн Аудитын газрын 7056-2147 тоот утсаар харилцана уу. Хаяг Хэнтий аймгийн Аудитын газар. Аймгийн ЗДТГ-ын байр. 325 тоот өрөө	Агуулга	
	Товчилсон үгийн тайлбар	
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	
	Ерөнхий мэдээлэл	
	Нэгдүгээр бүлэг: Байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулах зардлыг хуульд заасны дагуу бүрдүүлээгүй байна.	
	Хоёрдугаар бүлэг: Байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төлөвлөгдсөн ажил бүрэн хийгдэж дуусаагүй байна.	
	Гуравдугаар бүлэг: Аймгийн байгаль хамгаалах салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг үнэлэх боломжгүй байна.	
	Аудитын дүгнэлт	
	Аудитын зөвлөмж	
	Үндэсний Аудитын газарт хүргүүлэх санал	
	Аудитын тайлангийн төсөлд ирүүлсэн холбогдох байгууллагын санал	
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн саналд өгөх тайлбар	
	Аудитаар илэрсэн зөрчил ба акт, албан шаардлагын жагсаалт	
	Аудитын тайлангийн баталгаажуулалт	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮГИЙН ТОВЧЛОЛ	ТОВЧЛОСОН ҮГИЙН ТАЙЛАЛ
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТХГ	Тусгай хамгаалалттай газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
БХНСЗ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал
НАТО	Нөөц ашигласны төлбөрийн орлого
УЦУОШТ	Ус цаг уур орчны шинжилгээний төв
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ААН	Аж ахуйн нэгж
БНГ	Байгалын нөөц газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Нэг: Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дахь заалт, Монгол улсын Ерөнхий Аудиторын “Төлөвлөгөө батлах тухай” 2016 оны 01 дүгээр сарын 13-ны А/05 тушаалын 2 дугаар хавсралт, Хэнтий аймгийн Тэргүүлэх Аудиторын баталсан “Байгууллагын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Хоёр: Аудитын зорилт

2015 оны аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, байгаль хамгаалах салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг аймгийн ИТХ, Засаг дарга танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- *Аймгийн байгаль хамгаалах сангийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлсэн эсэх;*
- *Аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажил бүрэн хийгдэж дууссан эсэх;*
- *Аймгийн байгаль хамгаалах салбарт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр үр дүнтэй эсэх*

Гурав: Аудитын хамарсан хүрээ

Аудитаар Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Галшар, Баянмөнх, Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Батширээт, Биндэр, Дадал, Норовлин, Батноров, Бор-Өндөр, Баян-Овоо, Хэрлэн сумдын ЗДТГ-ыг хамруулан 2015 онд аймгийн Байгаль орчны салбарт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт болон байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн хөрөнгө, түүний зарцуулалтын гүйцэтгэл, санхүүжилт зэргийг хамруулан гүйцэтгэв.

Дөрөв: Аудитын арга зүй, стандартын талаах мэдээлэл

Аудитыг АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Тав: Аудит хийсэн хугацаа:

Аудитын төлөвлөх үе шатны ажлыг 2015 оны 5 дугаар сарын 2-ээс 18-ны хооронд хийж, гүйцэтгэх үе шатны ажлыг 5 дугаар сарын 19-аас 6 сарын 21-ны хооронд, тайлагнах үе шатны ажлыг 6 сарын 22-ээс 27-ны хооронд хийж холбогдох байгууллагаас саналыг авч, аудитын дүн, тайланг аймгийн Аудитын газрын Удирдлагын зөвлөлд 2016 оны 07 дүгээр сарын 20-нд шинжээч Д.Эрдэнэбилэг танилцуулав.

Аудитын тайлангын үед шинжээч Д.Эрдэнэбилэг өвчтэй байснаас 7 хоногоор хугацаа хойшилсон, үндэсний их баяр наадам таарснаас тайлангийн хугацаа хойшилсон.

Долоо: Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин хянан удирдаж, аудитын менежер Б.Наранцэцэг стандартыг хангуулж, Ахлах Аудитор Н.Туяа аудитыг зохион байгуулж, шинжээч Д.Эрдэнэбилэг хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 3.1 “Энэ хуулиар байгалын ургамал, ус, ой, ан амьтны нөөцийг ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг зохицуулна” гэж заасан байна.

Монгол улсын Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.1 “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, байгалын нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаар болон дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

Аймгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх ажилд 2015 онд ургамал, ус, ой, ан, амьтны нөөц ашигласны төлбөр болон ТХГ-т газар ашигласны төлбөрийн орлогоос нийтдээ 1284.9 сая төгрөг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1096,8 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

2015 онд байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар 235,6 сая төгрөгийн ажил хийгдсэн байна.

2015 онд хийгдэхээр төлөвлөгдсөн ажлуудаас 81,4 сая төгрөгийн 8 ажил 2016 онд шилжин хийгдэхээр болсон байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

• БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АЖИЛД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ БҮРДҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

1.1. Аймгийн байгаль хамгаалах сангийн орлогыг нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Хэнтий аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас аймгийн 2015 оны байгалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө 2014 оны газар, ус, ангийн орлогийн гүйцэтгэлийн 50-80%-иар тооцсон бол ойн орлогыг 2,1 дахин нэмэгдүүлэн тооцсон байна.

Аймгийн БОАЖГ нь 2015 оны орлогыг 2014 оныхоос 106%-иар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

д/д	Орлогын төрөл	2014 оны гүйцэтгэл	2015 оны БОАЖГ-ын төлөвлөгөө	Өсөлт/бууралт
1	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	174022,8	364353,7	+210%
2	Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	600820,6	534450,0	-0,8%
3	Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	84287,5	39532,0	-0,5%
4	Газрын төлбөр	126215,5	106233,2	-0,8%
	Бүгд	985346,4	1044568,9	+106%

2015 онд ойн нөөц ашигласны орлогийн өсөлт гарахад нөлөөлсөн хүчин зүйл нь Монгол улсын Засгийн газрын 2014 оны 307 дугаар тогтоолоор ойгоос ашигласан модны төлбөрийн хэмжээг 2,2 дахин өссөнөөс ойн орлого өсөж төлөвлөгдсөн байна.

1.2. Сангийн яамны хянасан ой, газрын орлогыг ИТХ-аар батлуулахдаа хэт ихээр нэмэгдүүлсэн байна.

Аймгийн БОАЖГ-аас боловсруулсан 2015 оны байгалын нөөц ашигласны төлбөрийн орлогын анхны саналыг аймгийн СТСХэлтэс бууруулан, Сангийн яаманд 846,2 сая төгрөгөөр хянуулсан байна.

Гэсэн хэдий ч аймгийн ИТХ-аар дээрхи ой, ус, ан, газрын орлогийг батлахдаа усны орлогийг 5,0 сая төгрөгөөр бууруулсан бол ойн орлогийг 188,8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ангийн орлогийг 25,4 сая төгрөгөөр, ус, рашаан ашигласны орлогийг 104,4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, нийтдээ 318,6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн байгалын нөөц ашигласны төлбөрийн орлогийг 1164,7 сая төгрөгөөр батлуулсан байна.

Улмаар аймгийн ИТХ-ын 2015 оны 2 сарын 9-ны XIV хуралдааны 01 тогтоолоор байгалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос ус, рашаан ашигласны болон газрын төлбөрийг орлогыг өөрчлөөгүй бол ойн нөөц ашигласны орлогийг 55,5 сая төгрөгөөр бууруулж,

ан амьтны нөөц ашигласны орлогийг 190,7 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт дүнгээр 135,2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

2015 он, сая төг

д/д	Орлогын төрөл	БОАЖГ-ын төлөвлөсөн	СЯ-ны хянасан	Аймгийн ИТХ-ын баталсан	Аймгийн ИТХ-ын тодотгосон	Гүйцэтгэл
1	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	165,1	166,0	354,8	299,3	252,6
2	Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	534,4	534,4	638,8	638,8	408,0
3	Амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	39,5	39,5	64,9	255,6	269,8
4	Газрын төлбөр	106,2	106,2	106,2	106,2	166,3
	Бүгд	845,2	846,2	1164,7	1299,9	1096,8

Аймгийн БОАЖГ-ын боловсруулсан 2015 оны ой, ус, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын төлбөрийн орлогийг тооцсон анхны санал 1044,5 сая төгрөг нь жилийн эцсийн орлогын гүйцэтгэл 1096,8 сая төгрөгтэй харьцуулахад орлого биелэх боломжтойгоор төлөвлөсөн байсныг бууруулсан гэж үзэж байна.

1.3. Байгаль хамгаалах үйл ажиллагааны зардлыг хуулийн дагуу тооцоогүй байна.

Хэнтий аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас төлөвлөсөн 2015 оны байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлыг Сангийн яам хянахдаа “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн¹ дагуу тооцож хянасан байна.

Харин аймгийн ИТХ-аар батлахдаа газрын төлбөрийн орлогоос байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн хувийг хуулийн дагуу тооцсон бол ойн нөөц ашигласны орлогоос БХНС3-д тооцох хувийг 39,8%-иар, ус рашаан ашигласны төлбөрийн орлогоос БХНС3-д тооцох хувийг 23,9%-иар, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос БХНС3-д тооцох хувийг 30,4%-иар тооцсон нь дээрхи хуулийг мөрдөөгүй байна.

Улмаар аймгийн ИТХ-ын 2015 оны 2 сарын 9-ний XIV хуралдааны 01 тогтоолоор байгалын нөөц ашигласны төлбөрийг тодотгон өөрчилсөн боловч газрын төлбөрийн орлогоос БХНС3-д зарцуулах хувийг хэвээр үлдээсэн бол ойн нөөц ашигласны орлогоос БХНС3-д тооцох хувийг 47,1%-иар, ус рашаан ашигласны төлбөрийн орлогоос БХНС3-д тооцох хувийг 23,9%-иар, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос БХНС3-д тооцох хувийг 7,7%-иар тус тус тогтоосон байна.

Ийнхүү “байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийг мөрдөөгүйгээс 2015 онд Хэнтий аймгийн байгалын нөөц ашигласны орлогоос БХНС3-д зарцуулах зардлыг хуулийн дагуу тооцоогүйгээс байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах зардалд 187,8 сая төгрөг дутуу хуваарлигдан батлагдсан байна.

¹ 18.1 “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалын баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: “Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогийн 85%, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогийн 35%, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогийн 50%, газрын төлбөрийн орлогийн 15%-ийг БОХНС3-д зарцуулна,

/сая.төг/

д/д	Орлогын төрөл	Хуваарлигдсан зардал	Орлогын төлөвлөлт			
			Анх батлагдсан		Тодотгосон	
			орлого	хувь	орлого	хувь
1	Ойн НАТО	141,1	354,8	39,8	299,3	47,1
2	Ус, рашааны НАТО	152,7	638,8	23,9	638,8	23,9
3	Амьтны НАТО	19,7	64,9	30,4	255,6	7,7
4	Газрын төлбөр	15,9	106,2	15,0	106,2	15,9
	ДҮН		1164,7		1299,9	

2015 оны жилийн эцсийн байдлаар байгалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос ус, рашаан ашигласны төлбөрийн орлогоос БХНСЗ-д зарцуулах зардал хуульд заасан хувийг мөрдсөн бол бусад орлогоос тооцох зардлыг дутуу тооцсон ба нийт дүнгээр 187,8 сая төгрөгийг дутуу хуваарилсан байна.

/сая.төг/

д/д	Орлогын төрөл	Орлогын гүйцэтгэл	Хуваарлигдсан зардал	Хуулиар байвал зохих	зөрүү
1	Ойн НАТО	252,6	141,1	214,7	-73,6
2	Ус, рашааны НАТО	408,1	152,7	142,8	+9,9
3	Амьтны НАТО	269,8	19,7	134,9	-115,1
4	Газрын төлбөр	166,3	15,9	24,9	-9,0
	ДҮН	1096,8	329,4	517,4	187,8

ХОЁРДУГААР БҮЛЭГ

•БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ЧИГЛЭЛЭЭР ТӨЛӨВЛӨГДСӨН АЖИЛ БҮРЭН ХИЙГДЭЖ ДУУСААГҮЙ БАЙНА.

2.1 Байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төлөвлөгдсөн ажил бүрэн хийгдэж дуусаагүй байна.


Байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төлөвлөгдсөн 48 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээг 2016 онд хэрэгжүүлж дуусгахаар хойшлуулсан бол үлдсэн 44 төсөл, арга хэмжээг 2015 онд гүйцэтгэж дуусгасан байна.

Тус 44 төсөл, арга хэмжээний санхүүжилт 235,4 сая төгрөгийг бүрэн санхүүжүүлсэн бол 4 төсөл, арга хэмжээний 55,5 сая төгрөгийн ажлын санхүүжилтийг 2016 онд хийгдэх ажилд тусган санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

2015 онд хэрэгжсэн нийт 44 төсөл, арга хэмжээний биелэлт 90,9%-тай байгаа ба 4 төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

Чингис хотын цэвэр усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажилд “Хэнтий-Ус” ХХК шалгарч урьдчилгаа санхүүжилт авсан боловч ажил хийгдэж эхлээгүй байна.

2015 онд хэрэгжсэн нийт 43 төсөл, арга хэмжээнээс Батноров суманд байгуулах ногоон байгууламж оройтсон, УЦУОШТ-д олгосон хүлэмжийг татаж авчраагүй, Онон голын сав газарт усны тооллого дутуу хийгдсэн бол бусад ажлууд бүрэн хийгдэж улсын комисс хүлээн авсан байна.



Мөн санхүүжилт хүрэлцээгүйн улмаас зарим төсөл, арга хэмжээг 2016 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан байна.

Чингис хотын нийтийн хог цэвэрлэгээний машин худалдан авах, Чингис хотын нийтийн хог цэвэрлэгээ, хог дарж булах ажлын шатахуун, Хэрлэн голын эрэгт цөөрмийн хашаажуулалт, Өмнөдэлгэр, Норовлин, Баянмөнх сумдын унд ахуйн худагт ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурьшуулах ажил санхүүжилтгүйн улмаас 2016 онд хэрэгжихээр болж хойшилсон байна.

2.2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төлөвлөгдсөн ажлуудын ХАА-г хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 2015 онд хийгдсэн нийт төсөл, арга хэмжээнээс 3 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, үлдсэн 41 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн байна.

Эдгээр төсөл, арга хэмжээ нь ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу харьцуулалтын аргаар тендер зарлах үнийн дүн бүхий 6 төсөл арга хэмжээнээс 3 ТАХ-г харьцуулалтын аргаар дүгнэсэн бол 2 ТАХ-г ШГБ, харин 1 ТАХ-г 2016 онд санхүүжүүлэхээр хойшлуулсан байна.

Хилийн зурваст түймрээс хамгаалах шороон зурвас татах ажил нь улсын нууцтай холбоотой ажил тул ТБОНӨХБАҮХАТХуулийн үйлчлэлд хамаарахгүй² тул хилийн цэргийн 0287-р ангитай шууд гэрээ байгуулан, Хэрлэн голын сав газарт уст цэгийн тооллого зохион байгуулах ажилд гүйцэтгэгч шалгараагүйн улмаас тухайн сав газрын захиргаагтай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

2015 онд байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төлөвлөгдсөн ажилд өөрчлөлт орж 1 ТАН-г 2015 оны 12 сард тендерийг зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулан ажлыг 2016 онд гүйцэтгэхээр болж санхүүжилтийн урьдчилгааг олгосон байна.

Өндөрхаан хотын ундны эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажилд “Хэнтий-Ус” ХХК шалгарсан боловч өнөөдрийг хүртэл ажлаа эхлээгүй байна.

Бусад 41 төсөл, арга хэмжээ нь Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68-р тушаалаар баталсан хавсралтад дурьдсан шууд худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаарт хүрээгүй тул гүйцэтгэгч байгууллага, ААН-тэй шууд худалдан авалтыг хийсэн байна.

Дээрхи худалдан авалтын дүнд санхүүгийн хэмнэлт гараагүй байна.

2.3 Байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төлөвлөгдсөн ажлуудын санхүүжилт бүрэн олгогдоогүй байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр төлөвлөгдсөн 48 төсөл, арга хэмжээнээс 55,5 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ санхүүжилт хүрэлцээгүйн улмаас 2016 онд санхүүжилтийг олгохоор хойшлуулсан бол үлдсэн 44 төсөл арга хэмжээний 235,4 сая төгрөгийг 2015 онд санхүүжүүлсэн байна.

Үүнээс амьтны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх 14 төсөл, арга хэмжээнд 12,4 сая төгрөг, ойн нөөц хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 10 төсөл арга хэмжээний 75,9 сая төгрөг, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашигласан төлбөрөөс 15,5 сая төгрөгийг буцаан тухайн бүсд 2 төсөл, арга хэмжээнд, тус тус төлөвлөсний дагуу бүрэн санхүүжүүлсэн бол ус рашааны нөөц хамгаалах, нөхөн сэргээх 10 төсөл, арга хэмжээнд 84,5 сая төгрөгийг санхүүжүүлж, 1 төсөл, арга хэмжээний 18,0 сая төгрөгийг санхүүжүүлээгүй, газрын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх 1 төсөл, арга хэмжээний 15,0 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн бол бусад 6 төсөл, арга хэмжээнд 32,1 сая төгрөгийг санхүүжүүлж нийт дүнгээр 44 төсөл арга хэмжээний 235,4 сая төгрөг санхүүжиж, 1 төсөл, арга хэмжээний 15,0 сая төгрөгийг 2016 онд санхүүжүүлэхээр болсон байна.

№	ТАХ-ний чиглэл	Бүрэн санхүүжсэн ТАХ		Дутуу болон санхүүжүүлээгүй ТАХ		Нийт ТАХ	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Амьтны чиглэлээр	14	12,4	-	-	14	12,4
2	Ойн нөөцийг хамгаалах чиглэлээр	10	75,9	-	-	10	75,9
3	ТХГ-т зарцуулсан	2	15,5	-	-	2	15,5

² 3.4.Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

4	Ус, рашааны чиглэлээр	10	84,5	1	15,0	11	99,5
5	Газрыг нөхөн сэргээх чиглэлээр	1	15,0	-	-	1	15,0
6	Бусад ТАХ-нд	6	32,1	-	-	6	32,1
	Нийт	43	235,4	1	15,0	44	250,4

Өндөрхаан хотын цэвэр усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажилд 2015 онд төлөвлөсөн зардлаас тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг хэтэрсэн тул “Хэнтий-Ус” ХХК-д 25,0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг 2015 онд санхүүжүүлэн үлдэгдэл санхүүжилтийг 2016 онд шийдвэрлэхээр болжээ.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас байгаль хамгаалагчдын өвлийн хувцасны зардал 17,7 сая төгрөгийг санхүүжүүлж чанарын шаардлага хангахгүй хувцас нийлүүлсэн учир үлдэгдэл санхүүжилтийг хассан байна.

“Мянган мөөжгий” ХХК нь чанарын шаардлага хангаагүй байгаль хамгаалагчдын зуны хувцасны 4,3 сая төг, гуталны 3,2 сая төг-ийн үлдэгдэл санхүүжилтийг тус тус олгоогүй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

•АЙМГИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САЛБАРТ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙГ ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

3.1 Аймгийн байгаль хамгаалах салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийг үнэлэх боломжгүй байна.

2015 оны байдлаар Хэнтий аймагт 4 төрлийн төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнд:

а/ НҮБХХ, Дасан зохицох сан “Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь” МОН/12/301 төсөл,

б/ WWF/Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дах газраас хэрэгжүүлсэн ажил,

в/ TNC төсөл,

г/ GCP/MON/008/GEF “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх нь” төслүүд хэрэгжсэн байна.

Дээрхи төслүүдээс “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд 2015 онд нийтдээ 20,0 гаруй сая төгрөгийг төсөл арга хэмжээнд зарцуулсан бөгөөд үүний 12,0 сая төгрөг нь сум дундын ойн ангийг бэхжүүлэхэд зориулж хөрөнгө бэлдсэн байна.

Өмнөдэлгэр, Батширээт сумдын ойн ангид мэдээллийн төв байгуулан ширээ, сандал, компьютер, бусад тоног төхөөрөмж олгосон байна.

Энэ хугацаанд 5 удаагийн сургалтыг 26 нөхөрлөлийг хамруулан зохион байгуулжээ.

TNC төслийн хүрээнд Норовлин сумын нутагт орших “Тосон хулстайн” БНГ-т үйл ажиллагаагаа явуулдаг ба 2,0 сая төгрөгийг 2 суманд гал унтраах тоног төхөөрөмжид зарцуулсан байна.

Норовлин сумын ЗДТГ-т 2ш, нөхөрлөлүүдэд 2ш, Баян-Овоо сумын ЗДТГ-т 2ш, нөхөрлөлүүдэд 4 ш гал унтраагч олгосон байна. Мөн дохиололтой хүзүүвчийг 10 зээрэнд зүүсэн байна.

Тус төслөөс нийтдээ 2015 онд 15,5 сая төгрөгийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан ба тоног төхөөрөмжид зарцуулснаас бусад 13,5 сая төгрөгийг шинжилгээ, сургалт болон үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулсан байна.

Баян-Овоо сумын “Гүрмийн нуур”-ын усыг 3,5 сая төгрөгөөр шинжилгээ хийлгэсэн.

“Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь” төслийн хүрээнд булгийн эх хаших, ойжуулалт хийх, амьтан сэргээн нутагшуулах зэрэг ажлыг хийсэн байна.

Баян-Адарга сумын мод үржүүлгийн талбай байгуулж, 20 га-д ойжуулалт хийсэн. Мөн Норовлин сумын Баян-Өлзийт багийн “Могойтын ам” газарт 30 тарвага нутагшуулсан байна.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь газраас ан амьтны шилжилт хөдөлгөөний судалгаа хийх, төлөвлөгөө боловсруулах, түймэр унтраах, булаг сэргээн засварлах, биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хууль бус агнууртай тэмцэх, мод тарих, усны нөөцийг хамгаалах чиглэлээр тус тус ажлууд хийгдсэн байна.

Хар ямаатын БНГ-ын хамгаалалтын захиргааны хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 36 м2 ажлын байр, Ланд круйзер-77 маркийн автомашин, 4ш мотоцикль олгосон байна.

“Онон голын нөхөрлөлүүдийн нэгдсэн холбоо” ТББ-тай хамтран Онон гол сав газрын 7 сумдын 130 гаруй нөхөрлөлүүдэд дэмжлэг үзүүлж, 4 удаагийн сургалт зохион байгууллаа.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь Хар ямаатын БНГ-т чиглэн явагддаг байна.

Хэнтий аймагт тогтмол ажилтангүй төслүүдийн хувьд санхүүгийн мэдээлэл хязгаарлагдмал, үйл ажиллагаа нь аль нэг аймгийн дагнан явагддаггүй тул үйл ажиллагааг нь зөвхөн Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт хийгдсэн ажлаар салгах боломжгүй байна.

3.2 Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа ажилд тавих хяналт сул байна.

Хэнтий аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа дээрхи 4 төсөл, арга хэмжээнээс 1 төслийн ажилтан аймгийн БОАЖГ-т байрлан ажилладаг бол бусад 3 төсөл нь аймгийн БОАЖГ-тай хамтарсан байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг тогтмол ажилладаг ажилтан тус аймагт байхгүй юм байна.

“Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх нь” төслийн ажилтан аймгийн БОАЖГ-т байрлан ажилладаг байна.

Хэнтий аймагт тогтмол ажилтантай төслийн хүрээнд хийгдэж байгаа ажилд тавих хяналт болон тус төсөлтэй ажлын холбоотой ажиллах талаар аймгийн БОАЖГ хамтран ажиллаж байгаа бол бусад 3 төслийн хүрээнд хийгдэж байгаа ажлын мэдээлэл авах хэлбэрээр хязгаарлагдаж байна.

Төслийн хүрээнд хийгдэж байгаа ажлууд нь хэд хэдэн аймгийн нутгийн дамнан явагддаг тул аймгийн зүгээс бүхэлд нь хяналт тавих боломжгүй байна.

3.3. Байгаль орчны салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар мэдээлэл иргэдэд хүрэхгүй байна.

Хэнтий аймгийн байгаль орчны салбарт хэрэгжиж байгаа 4 төслүүдээс “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх нь” төслөөс 2015 онд 6 удаагийн уулзалтаар 26 нөхөрлөл, 200 гаруй иргэдэд мэдээлэл өгсөн байна.

Бусад төслүүдийн тухайд аймгийн БОАЖГ-т хийсэн ажлын танилцуулгаа ирүүлдэг бөгөөд иргэдэд мэдээлэл хийсэн талаар тодорхойгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

- Байгалийн нөөц ашигласны орлогоос байгалын нөхөн сэргээлтэд зарцуулах хувийг батлахдаа хуульд заасан хувиар тооцохгүй байна,
- Батлагдсан төсөл, арга хэмжээнүүд бүрэн хэрэгжээгүй байна,
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Хэрлэнчимэг-т

- Байгалийн нөөц ашигласны орлогоос байгалын нөхөн сэргээлтэд зарцуулах зардлыг хуульд заасны дагуу хуваарилан, төсөвт тусган батлуулах ажлыг 2016 оноос эхлэн хэрэгжүүлэх,

Аймгийн БОАЖГ-ын дарга Г.Энхбаяр-т

- Байгалийн нөхөн сэргээлтээр батлагдсан төсөл, арга хэмжээний хяналтыг улирал тутам хийж, хэрэгжилтийн дүнг 2016 оны 11 сард багтаан бүрэн хэрэгжүүлсэн дүнг танилцуулах,

Аудитын тайланд дурьдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр авах арга хэмжээ, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2016 оны 09-р сарын 01-ны дотор албан бичгээр, хийгдсэн ажил, үр дүнгийн талаарх мэдээллийг 2016 оны 12 сарын 20-ны дотор гаргаж албан бичгээр ирүүлэхийг мэдэгдье.

ТАЙЛАН БИЧСЭН:

Шинжээч

Д.Эрдэнэбилэг

2016 оны 07 дугаар сарын 20

Хавсралт №1:

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛСЭН ТООТ


**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬГА
ХЭНТИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**
23118 Хэнтий аймаг, Харлан сум, Сариг баяр
Утас: 70-56-21-47, Факс: (976) 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2016.07.07 № 150
талай -ы № -т

АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
Г.ЭНХБАЯР ТАНАА

Аймгийн ИТХ-ын захиалга, аймгийн Аудитын газрын 2016 оны ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр арга хэмжээний үр дүн”-д хийж байгаа гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүргүүлэв.

Аудитын тайланг аймгийн Аудитын газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар 2016 оны 7 сарын 8-нд хэлэлцэх тул энэ хугацаанд багтаан саналаа ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.ЭНХТҮВШИН




**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬГА
ХЭНТИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**
23118 Хэнтий аймаг, Харлан сум, Сариг баяр
Утас: 70-56-21-47, Факс: (976) 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2016.07.07 № 149
талай -ы № -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА С.ХЭРЛЭНЧИМЭГ
ТАНАА

Аймгийн ИТХ-ын захиалга, аймгийн Аудитын газрын 2016 оны ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр арга хэмжээний үр дүн”-д хийж байгаа гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүргүүлэв.


Аудитын тайланг аймгийн Аудитын газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар 2016 оны 7 сарын 8-нд хэлэлцэх тул энэ хугацаанд багтаан саналаа ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.ЭНХТҮВШИН



Хавсралт №2

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ

Холбогдох байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн санал	Тайлбар
 Холбогдох байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн санал Хариу хүргүүлэх тухай Тус байгууллагын 2015 оны “Байгаль орчныг хамгаалах сангийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр арга хэмжээний үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Уг гүйцэтгэлийн аудитаар 4 зөрчилтэй асуудал илэрсэн байна. Иймд эдгээр зөрчилтэй үнэлэгдсэн ажлуудыг бүрэн гүйцэтгүүлэх дараах саналыг хүргүүлж байна. Үүнд: - Бүх сум, тосгонд усны тооллого, хог хаягдлын тооллого зохион байгуулах, унд ахуйн худаг тус бүрт онцгой, энгийн, эрүүл мэндийн бус тогтоох - Аймгийн Засаг даргын 2015 оны 08 дугаар сарын 07-ны А/399 тоот захирамжаар “Уст цэгийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, БОАЖГ-ын даргын 2015 оны 08 дугаар сарын 24-нд баталсан “Тооллого зохион байгуулах ажил”-ын удирдамжийн дагуу тус ажил хийгдсэн. Уг ажлын зардлыг ажлын онцлогоос шалтгаалан Онон голын сав газрын захиргаанд 100 хувь шилжүүлсэн. Гэвч тус ажлын гүйцэтгэл хангалтгүй байсан тул 2016 оны 05 дугаар сарын 30-нд аймгийн Цагдаагийн газарт манай байгууллага нь хохирол барагдуулах тухай хүсэлтийг гаргуулан шалгуулж байна. - Чингис хотын уст цэгийг нэмэгдүүлэх, инженерийн байгууламж байгуулах - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тус ажлын төндөрийг зарласны дагуу гүйцэтгэгчээр “Хэнтий-Ус” ХХК шалгарч ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулж урьдчилгаа санхүүжилт болох 25 сая төгрөгийг урьдчилгаа болгон өгсөн. Гэвч тус ажил хугацаандаа хийгдээгүй тул 2016 оны 07 дугаар сарын 06-нд тус байгууллагатай нэмэлт гэрээ байгуулж ажлын гүйцэтгэлийн 2016 оны 11 дүгээр сарын 15-нд хүлээн авахаар болсон. - УЦУОША-нд хүлэмж авах 3.0 сая төгрөгөөр хүлэмж худалдан авах гэрээг “Бат хүлэмж” ХХК-тай 2015 оны 04 дүгээр сарын 11-нд байгуулсан. Гэвч УЦУОША нь тус хүлэмжийг санхүүгийн боломжоос шалтгаалан татан авчралгүй байсаар 2016 оны 07 дугаар сарын 01-нд авчирсан ба уг хүлэмжийг хүлээн авах ажлын хэсэг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдаж байна. - Батноров суманд 2 га ногоон байгууламж байгуулах - Уг ажлын зардал 5.0 сая төгрөг бөгөөд тус ажлыг гүйцэтгүүлэх гэрээг 2015 оны 12 дугаар сарын 11-нд байгуулсан ба ажил гүйцэтгүүлэх гэрээнд тус ажлыг 2016 оны 10 дугаар сарын 01-нд хүлээн авахаар тусгасан болно. Иймд эдгээр ажлуудыг 2016 онд бүрэн хийж хууль тогтоомжийн дагуу ажлын гүйцэтгэлийг хүлээн авч эргэн тайланыхыг мэдэгдэж байна. ДАРГА Г.ЭНХБАЯР	1. БОАЖГ-аас ирүүлсэн тоотоор зөрчлийг залруулах талаар санал ирээгүй тул тайланд өөрчлөлт орсонгүй.
Аймгийн СТСХ-ийн албан тоот ирээгүй	2. Аймгийн СТСХ-ээс “төрийн аудитын тухай хууль”-д³ заасан хугацаанд саналаа ирүүлсэнгүй.

³ 19.3.Аудит дуусаж, тайлангийн төсөл бэлэн болсны дараа төрийн аудитын байгууллага дараахь арга хэмжээ авна: 19.3.1. “Аудит хийлгэсэн байгууллагад тайлангийн төслийг өгч ажлын 10 хоногийн дотор саналаа өгөхийг хүсэх”;

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 24

Өндөрхаан

Гүйцэтгэлийн аудитын тайланг батлах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаалаар баталсан “Нийслэл болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх”-ийн 5, аймгийн Аудитын газрын Удирдах Зөвлөлийн 7 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хандив, тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг батласугай.
2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Н.Туяад даалгасугай.
3. Аудитын ажлыг үнэлж дүгнэн, үр өгөөжийг тооцож ажиллахыг аудитын менежер Б.Наранцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ЭНХТҮВШИН

1200050